

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2021оны 11 дүгээр сарын 01
Дархан

Аймгийн Засаг даргын захирамж -18, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал -17 санамж бичиг - 2, гэрээний төсөл- 3 үндэслэлийг тус тус хянаж зөвлөгөө өгч, Захирамж, тушаалд ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг гаргах шаардлагатай эсэхийг шийдвэрлэлээ.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй шалгалтын ажлын хэсэгт шаардлагатай мэдээ, тайланг холбогдох газар, хэлтэс, албадаас авч нэгтгэн боловсруулж цахим хуудсаар хүргүүлээ.

Сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч 59 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль тогтоомжоор сургалт зохион байгууллаа.

Архивын чиглэлээр

Нийт 126 иргэний хүсэлтийг хүлээн авч, тушаалын хуулбар-279, тодорхойлолт-33, нийт 312 лавлагаа гаргаж орон нутгийн төсөвт 714.000 /долоон зуун арван дөрвөн мянган төгрөг/ хураамжийн орлогыг төвлөрүүлээ.

1,45,46,49,98 хөмрөгийн 28 хадгаламж нэгжийн 1135 хуудаст сэргээн засварлалт фото шоп сэргээн засалт, задаргаа холболт хийсэн.

5 хөмрөгийн 91 хадгаламжийн нэгжийн 3288 хуудсанд сэргээн засварлалт хийж 35 хадгаламжийн нэгжийн 1018 хуудсанд фото шоп холболт хийсэн.

Шинээр ашиглалтанд орсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авах 19 улсын комисст ажиллан барилга байгууламжийн зураг төслийн баримт архивт хүлээлгэн өгөх аж ахуй нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаас гадна шинээр ашиглалтанд орсон барилга байгууламжийн 2 байгууллагаас 8 хадгаламжийн нэгж зураг төслийн баримтыг цаасан суурьтайгаар акт үйлдэн хүлээн авснаас гадна зураг төслийн баримтыг 1 ширхэг CD-нд буулгуулан хүлээн авч бүртгэл үйлдлээ.

Архивын тасгийн үе үеийн дарга нарын ажлын холбогдолтой 22 хадгаламжийн нэгж баримтыг товъёг үйлдэн үдэж хавтасласан.

Аймгийн Засаг даргаас ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн Г.Энхсайханаар хүлээлгэн өгсөн Дархан – Сэлэнгийн эдийн засгийн бүсийн төлөвлөлтийн ерөнхий төсөл мөн Дархан хот төлөвлөлтийн төслийн тайлбар бичгүүдийг Орос болон Монгол хэлээр орчуулсан баримтуудын хамт нийт 14 хадгаламжийн нэгж баримтыг хүлээн авч үдэж хавтаслан хамгаалалтын хайрцагт хийн архивын сан хөмрөгт байрлуулсан.

Төрийн архивын улсын үзлэгээс өгсөн үүрэг даалгаврын дагуу хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төрийн архивын гадна болон дотор хуучин хяналтын камерыг сольж шинээр хадгаламжийн сангийн 2 өрөөнд 5 камер, корридор 2 камер тавьж, хамгаалалтын дохиололын системийг шинээр суурилуулсан.

Дархан-Уул аймгийн хэмжээнд хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, “Өршөөл үзүүлэх тухай хууль”-иар хугацааны өмнө суллагдсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, бүртгэл судалгаанд авах, тэдгээрийн гарын хээг авч гарын хээний санд баяжилт хийх, гутлын хээний санг шинээр үүсгэх ажлыг зохион байгуулж цаашид гэмт хэрэг зөрчлийг гарын хээ, гутлын мөрөөр илрүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн газартай хамтран “БҮРТГЭЛ-ХЯНАЛТ-2021” хэсэгчилсэн арга хэмжээг 2021 оны 09-р сарын 30-ны өдрөөс 10-р сарын 07-ныг хүртэлх хугацаанд хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд албаны дарга, криминалистикийн шинжээч, гарын хээний санч нар оролцож 28 хүний гарын дардас, 200 гаруй төрлийн гутлын хээний зургийг авч ажилласан.

Дохиолол хамгаалалтын “Тэнгэрийн бүргэд” ХХК нь тус албатай байгуулсан хамтран ажиллах гэрээний заалтыг удаа зөрчиж, албанаас тавьсан санал хүсэлтийг биелүүлээгүй тул гэрээг цуцалж 2021 оны 09-р сарын 13-ны өдрөөс эхлэн “Дархан-Шонхор” ХХК-ийн хамгаалалтын албатай гэрээг шинэчлэн байгуулж албаны байрны харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах ажил үүргийг хариуцуулж хамтран ажиллаж байна.

ЦЕГ-ын дарга болон ШШҮХ-ийн захирлын 2012 оны 385, А/278 дугаар тушаалаар батлагдсан “Хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам”-ын дагуу гэмт хэргийн дуудлагад оролцож байгаа шинжээч, шинжээч эмч, жолооч нар 26 ширхэг нэг удаагийн халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, амны хаалт, бээлий зэрэг зүйлийг стандартын дагуу өмсөж хэрэглэн хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган 41 хэргийн газарт очиж, үзлэгийг ул суурьтай чанартай хийж гүйцэтгэсэн.

Тус өдрүүдэд аймаг орон нутгийн хэмжээнд гарсан гэмт хэргийн шинжтэй 41 дуудлагад криминалистикийн шинжээч болон шинжээч эмч нар оролцож ажилласан талаарх мэдээллийг хүрээлэнгийн зохицуулагч нарт өдөр бүр танилцуулж ажилласан. Гэмт хэргийг өнгөөр нь авч үзвэл: Хүн амь учралын-11, хулгайн-4, ЗТО-12, бусад-14 удаа хэргийн газрын үзлэгт оролцож ажиллав. Хэргийн газраас гарын мөр-11 ширхэг, гутлын мөр 2, бусад эд мөрийн баримт-32 ширхгийг илрүүлж бэхжүүлэн заавар зөвлөмжийн дагуу савлаж битүүмжлэн, хаягжуулалтыг хийж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

Гарын хээний санч эрүүлжүүлэгдсэн болон саатуулагдсан, сэжигтэн, хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлсэн, гэмт хэрэг зөрчил гаргасан 105 хүний гарын дардсыг ажилласан байна.

Гарын мөрийн “Адис-Папилон” ажлын станцад гарын хээний дардас-111 ширхэг, гарын мөр-2 ширхгийг кодлон оруулж санг баяжуулсан. Албаны дарга, цагдаагийн хошууч Б.Түвшинтөр шинжээч нарын ажлын ачааллыг бууруулах зорилгоор гарын хээний санд маягт-2 цаасан дардсаар авагдсан 25 ширхэг гарын дардсыг сканердаж, живой сканераар авагдсан 31 дардсыг кодлон нэгдсэн санд илгээж илрээгүй хэргийн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөртэй хайлт хийж үр дүнг шалгаж ажилласан.

Гарын хээний сангаар 1 хулгайн хэргийг гарын мөрөөр нотлон тогтоосон байна.

Эрх бүхий байгууллага албан тушаалтны тогтоол захирамжийн дагуу криминалистикийн шинжээчид 2 шинжилгээг хийж дүгнэлт гарган ажилласан.

Энэ хугацаанд эрүүгийн байцаан шийтгэх бусад ажиллагаанд 11 удаа мэргэжилтнээр оролцож /цогцосны үзлэг, задлан шинжилгээнд 11/ ажилласан байна.

Шинжээч эмч нар эрх бүхий этгээдийн томилсон тогтоол шийдвэрийн дагуу 92 хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, бэлгийн холбогдолтой 9, цогцост задлан шинжилгээ 8 шинжилгээг хийж, дүгнэлт гарган ажилласан.

Тус алба нь шүүх эмнэлгийн лабораторид химийн 15, биологийн 13 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан

Шинжээч эмч нар нас барсан тухай 07 маягтыг иргэдийн хүсэлтээр 6 удаа гарган ар гэрт нь хүлээлгэн өгч ажилласан.

E-Nifs цахим бүртгэлийн системд хэргийн газрын үзлэгийн 41, криминалистикийн шинжилгээ 2, шүүх эмнэлгийн эмчийн үзлэг 92, задлан шинжилгээ-8, тусгай шинжилгээ-28 мэдээллийг тухай бүр бүртгэж ажилласан байна.

Улсын бүртгэл

Бүртгэлийн төрөл	Тухайн сар
1.1. Төрсний бүртгэл	172
1.2. Үрчилсний бүртгэл	2
1.3 Овог, эцэг/эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл	10
1.4 Эцэг тогтоосны бүртгэл	1
1.5 Гэрлэсний бүртгэл	14
1.6 Гэрлэлт цуцлуулсны бүртгэл	10
1.7 Засвар өөрчлөлтийн бүртгэл	2
1.8 Нас барсны бүртгэл	68
1.9 Өөр аймаг, нийслэлээс шилжин ирсний бүртгэл	102
1.10 Сум, баг хооронд шилжин ирсний бүртгэл	168
1.11 Гадаад паспорт олголт	133
1.12 Иргэний цахим үнэмлэх олголт	289
1.13 Регистрийн дугаарын өөрчлөлтийн бүртгэл	0
1.14 Зөвлөгөө өгсөн хүний тоо	85
1.15 Лавлагаа олгосон иргэний тоо	743
1.16 Байгууллага, аж ахуйн нэгжид олгосон лавлагаа	146
1.17 Архивын санд байрлуулсан хувийн хэрэг, ИУБ маягт	856

1.18 Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан хүний тоо		324
1.19 Гэрчилгээний дахин олголт		33
1.20 Илрүүлсэн зөрчил		0
1.21 Арилгасан зөрчил		0
Нийт үйлчилсэн	ААНБ	6
	ИРГЭН	2158
Эд хөрөнгийн эрхийн бүртгэл		
2.1. Худалдах гэрээний бүртгэл		254
2.2. Бэлэглэлийн гэрээний бүртгэл		25
2.3. Өв залгамжлах гэрээний бүртгэл		17
2.4.Хамтран өмчлөгч өөрчлөгдөх		12
2.5. Ү-өмчлөх эрх анх удаа баталгаажуулсан бүртгэл		63
2.6. Г-өмчлөх эрх анх удаа баталгаажуулсан бүртгэл		11
2.7. Лавлагаа олгосон		5
2.8. Барьцааны гэрээний бүртгэл		743
2.9. Бүртгэлд өөрчлөлт оруулах		60
2.10.Арилжих гэрээ		0
2.11. Тэмдэгтийн хураамж		1,527,543
2.12.Үйлчилгээний хураамж		14,395,253
2.13. ҮХЭХӨЭ-ээ худалдсан татварын орлого		129,280,970
2.14. Нийт хүлээн авсан мэдүүлгийн тоо		1406
Нийт үйлчилсэн	ААНБ	8
	ИРГЭН	1406
Хуулийн этгээдийн бүртгэл		
3.1 Хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах		12
3.2 Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах		15
3.3 Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх		28

3.4 Тамга тэмдгийн хяналтын хуудас олгох		17
3.5 Татан буугдсан, ашиглалтын шаардлага хангахгүй тамга, тэмдгийг хураан авах		0
Лавлагаа		5
Зөвөлгөө мэдээлэл, бусад		71
Нийт үйлчилсэн	ААНБ	158
Бүртгэлийн хяналт		
4.1 Захиргааны арга хэмжээ авсан хүний тоо		0
4.2 Торгуулийн дүн		0
4.3 Хүчингүй болгосон иргэний цахим үнэмлэх		0
4.4 Хүчингүй болгосон гадаад паспорт		0
4.5 Хүлээн авсан өргөдөл гомдол		0
4.6 Дүгнэлт шийдвэр гаргасан		0
4.7 Нийт үйлчилсэн иргэн		0
НИЙТ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН	ААНБ	172
	ИРГЭН	3564

ХХААХҮЯ, түүний харьяа Малын удмын сангийн үндэсний төв, Хөдөө аж ахуйн бирж, Хөдөө аж ахуйг дэмжих сантай хамтран малынхаа чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилготой иргэн, аж ахуйн нэгжүүдэд зориулсан дуудлага худалдааг тус аймгийн Хонгор суман дахь МУСҮТөвд анх удаа зохион байгууллаа. Уг дуудлага худалдаагаар Франц улсаас импортоор авч Монгол Улсад нутагшуулсан гойд ашиг шимт махны чиглэлийн Ангус, Лиммузин үүлдрийн үхэр, мах-ноосны чиглэлийн нарийн ноост Меринос, Суффольк, Романов, Бирешон үүлдрийн хонийг худалдан борлуулсан юм. Энэхүү үйл ажиллагаанд Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Хэнтий зэрэг аймгаас 50 орчим аж ахуйн нэгж, иргэн хүрэлцэн ирж, малынхаа үүлдэрлэг, таваарлаг байдлыг сайжруулах чиглэлээр мэдээ, мэдээлэл авлаа. Мөн дуудлага худалдаанд оролцохоор 9 иргэн, аж ахуйн нэгж бүртгүүлж, нийт 3 үхэр, 1 хонь борлуулсан байна.

Аймгийн хэмжээнд 58,6 мянган тонн байгалийн хадлан бэлтгэхээс 21-ны өдрийн байдлаар 88,3 хувь буюу 51,7 мянган тонн хадлан бэлтгээд байна.

Хүнсний боловсруулах 59 хүнсний үйлдвэр, Орхон сумын 13, Хонгор сумын 20, Шарын гол сумын 33, Дархан сум 245 хүнсний дэлгүүрийн үнэ, бүтээгдэхүүний үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн 1, 4 дахь өдрүүдэд тогтмол авч, хангамжийг хоногоор тооцож, ХХААХҮЯ, аймгийн Онцгой байдлын газарт 68 дахь удаагаа хүргүүлэн ажиллав. 2021.10.18-ны өдрийн байдлаар хангамж тооцоход малын мах 11.65, гурил 868.01, гурилан бүтээгдэхүүн 3.2, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 16.3, төмс 9.88, хүнсний ногоо 5.28, будаа 22.55, тос 37.6, элсэн чихэр 100.5, давс 902, өндөг 1.2, савласан цэвэр ус 1.82, цай 1.32 хоногийн нөөцтэй байна.

Аймагт үйл ажиллагаа явуулж буй 3 гурилын үйлдвэрт буудайн үлдэгдэл нийт 55570.2т, хивэг 1541.5т үлдэгдэлтэй байна. Тээвэр Дархан ХХК-ийн хүнсний захын махны тасагт мал, мах бэлтгэгч нар 2021.01.23-2021.09.30-ний хугацаанд нийт 636.1тн мах нийлүүлснээс 445.1 тн борлуулсан ба үлдэгдлийг үйлдвэр, цехэд нийлүүлсэн байна. 2021.10.01-2021.10.18-д нийт 65.2тн мах нийлүүлж, 45.6тн борлуулж, бусад махыг үйлдвэр цехэд нийлүүлсэн байна.

Дархан-Уул аймагт Малын махны нөөц бүрдүүлэх /200тн/ сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллаж, техникийн тодорхойлолтыг хэлэлцэж, хурлын тэмдэглэл үйлдлээ. Сонгон шалгаруулалтыг 2021 оны 10-р сарын 20-ны өдрөөс 11 дугаар сарын 01-ний өдрийн 12:00 цаг хүртэлх хугацаанд зарлалаа.

Төвийн бүсийн түншлэл-2021” үзэсгэлэн худалдаа 10-р сарын 14-нөөс 16-ны өдрүүдэд Спортын ордон, Найрамдал талбайд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Энэ удаагийн үзэсгэлэн худалдаанд 63 ААНБ, иргэн оролцож, 84.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2021 онд аймгийн хэмжээнд нийт 20804 га талбайд тариалахаар төлөвлөснөөс 24590.6 га-д буюу 3786.6 га-аас илүү тариалсан байна.

Тус аймгийн Орхон суманд 2021 оны 06 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд орсон их хэмжээний хур тунадасны улмаас 3 аж ахуйн нэгж, 121 иргэний 319.3 га талбайд тариалсан төмс, хүнсний ногоо үерийн усанд өртсөн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18 ны өдрийн 01-А/180 дугаар захирамжаар байгуулсан үер усны гамшигт нэрвэгдсэн тариаланчдын хохирлыг тогтоох, нөхцөл байдлын дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг томилогдсон ажилласан бөгөөд 2 аж ахуйн нэгж, 64 иргэнд учирсан хохирлын хэмжээг тогтооход 589.0 сая төгрөгийн бодит хохирол учирсан байна.

Энэ жил урьдчилсан балансар 16571.4 га-аас 26437.1 тонн буюу га-аас 16.0 цн улаан буудай хураан авах төлөвтэй байна. Үүнээс 1840 тонныг нь ирэх оны тариалалтад, 1200 тонныг нь үрийн нөөцөд, 1080 тонныг тэжээлд, 22317 тонныг гурилын үйлдвэрлэлд нийлүүлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна. Төмс 501.3 га-аас 8271.4 тонн буюу га-аас 165 цн, хүнсний ногоо 1146 га-аас 16284.7 тонн буюу га-аас 14261 цн, 5730 га-аас 1833 тонн буюу га-аас 3.2 цн тосны ургамал, 992 га-аас 2084.3 тонн буюу га-аас 21 цн ургац хурааж авах урьдчилсан тооцоог гаргалаа.

Урьдчилсан байдлаар улаан буудайн ургац өмнөх оны гүйцэтгэлээс 10686 тонноор, төмс 1882 тонноор, хүнсний ногоо 2104 тонноор, тосны ургамал 409 тонноор, малын тэжээл 596 тонноор тус тус илүү ургац хураан авах урьдчилсан баланстай байна.

Уринш боловсруулалтыг өнөөдрийн байдлаар үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 51 аж ахуйн нэгж, 62 иргэн 9540.8 га талбайд хийгдсэн байна.

Намрын ургац хураалтанд үр тарианы 45 комбайн, төмс хүнсний ногооны 28 хураагч техник ажиллахаар техник засварын ажил бүрэн хийгдсэн дүнтэй байна. Техникийн хүчин чадлын тооцоог хийж үзвэл хураалтыг цаг уурын ямар нэгэн хүндрэл гарахгүй бол 15-21 хоногт хийж гүйцэтгэхээр байна.

Өнөөдрийн байдлаар аж ахуйн нэгжүүд их дээд сургуулийн удирдлагуудтай гэрээ байгуулан үр тарианы хураалтанд уртын дадлагын 9 оюутан, төмс хүнсний ногооны хураалтанд Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн түр ажилтан 126, их сургуулийн 226 оюутан, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 96 иргэн 4 аж ахуйн нэгж, 12 иргэний талбайд ажиллаж байна. Төмс, хүнсний ногооны хураалтын ажил хэвийн хэмжээнд үргэлжилж байна.

2021 оны 10 дүгээр сарын 22-ны байдлаар ургац хураалтын ажил 75.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс буудай 12648,4 га-аас 16145,99 тонн, төмс 501,3 га-аас 6105,5 тонн, хүнсний ногоо 1080,27 га-аас 13428,9 тонн, малын тэжээлийн таримал 862 га-аас 1546,9 тонн, тосны ургамал 3176 га-аас 1240,1 тонн ургац тус тус хураан авсан дүнтэй байна.

Дархан-Уул аймгийн ургац хураалтын мэдээ											
											2021.10.22
д/д	Таримлын төрөл	Тарьсан талбай га	ургац алдсан /га	малын тэжээлд шилжсэн /га/	Ангилсан /га/	Цайруулсан талбай /га/	Шууд хураасан /га/	Нийт хураасан талбай /га/	Нийт ургац /тн/	Га-ын ургац	Хураалт %
1	Буудай	16571.4	780	0	5600	5600	7048.4	12648.4	16145.99	12.8	80.1
2	Төмс	525.5	24.2	0	0	0	0	501.3	6105.5	121.8	100.0
3	Хүнсний ногоо	1446.2	300.2	0	0	0	0	1080.27	13428.9	124.3	94.3
4	Тосны ургамал	5730	0	0	869	869	2307	3176	1240.1	3.9	55.4
5	Малын тэжээл	992.5	20	0	0	0	0	862	1546.9	17.9	86.9
НИЙТ		25265.6	1124.4	0.0	6469.0	6469.0	9355.4	18268.0	38467.4	0.0	75.6
		1146	501.3	24161.2	15791.4						
Мэдээ гаргасан мэргэжилтэн							О.НЭМЭХБАТ				

Аймгийн хэмжээнд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон 13 иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид угсралтын явцад нь Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.

Дархан ногоон хот дэд хөтөлбөр батлагдахтай холбогдуулан Дархан-Уул аймагт 20 сая мод тарих болсонтой холбогдуулан мод тарих газрын байршилын зураг төслийг хийж гүйцэтгэсэн.

Засгийн газрын 2021,07,20 өдрийн 212 дугаар тогтооллын дагуу барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэмийн дагуу улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.

1. Дархан сумын өргөө багт баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга
2. Дархан сумын 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд баригдсан хүүхдийн төмөр замын барилга
3. Дархан сумын 14-р баг Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд баригдсан алсыг харагч Дархан өргөө политехникийн коллежийн сургалтын дадлагын байрыг ашиглалтад оруулах комиссид оролцсон.
4. Дархан сумын 3-р баг Өсөх баян бүрд хаус ХХК,
5. Барил трейд ХХК-ны гадна цахилгаан хангамжийн эх үүсвэрт холбох ажилд комисс ажиллаж ашиглалтад оруулсан.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021/10/05-ны өдрийн №2/1895 албан тоотын дагуу ирүүлсэн ГЗБГЗЗГДаргын А/187 тоот тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад танилцуулсан. Иргэдийн газрын талаарх цахим системийг ашиглахад нь зориулж “**ЦАХИМ ТӨВ**” нээн ажиллуулж заавар зөвлөгөө, өгөх, албан хаагчдын хуваарийг батлан мөрдүүлж ажиллаж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөнд Дарханчууд нэгдэж, "Ногоон Дархан-2032" аймгийн хэтийн зорилтод 2032 он дуустал 20,0 сая мод тарих аянг эхлүүлж буйгаа аймгийн Засаг дарга Б.Азжаргал Дарханчууддаа танилцууллаа. Уг шийдвэрийн дагуу “Ногоон Дархан-2032” хэтийн зорилтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ёсчлон баталлаа.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг угтаж Модны тарьц, суулгацын худалдааг 2021 оны 10 дугаар сард 2 удаа “Олон улсын худалдааны төв”, “Дархан зах”-ын гадна талбайд зохион байгуулж давхацсан тоогоор 19 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцож, 18,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“Намрын мод тарих ажлыг 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн халдвар, хамгааллын дэглэмийг сахин хуваарийн дагуу хэсэгчилсэн байдлаар мод тарих ажлыг зохион байгуулсан. Үүнд: “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнгийн хөл бөмбөгийн талбайн гадна талбайд 350 ширхэг нарс мод тарилаа. Уг ажлыг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 64,0 сая.төгрөг гаргаж, гүйцэтгэлийг “Алд дэлгэм” ХХК хийж байна.

“Газар буудай” ХХК-ийн хамт олон 2.9 га газарт 765 ширхэг агч, нарс мод тарилаа.

“Ногоон паспорт-Ногоон төгөл”-д 7 байгууллагын 177 ажилтан албан хаагчид, 320 мод тарилаа. Уг төгөлд нийтийг хамарсан ажлын хүрээнд ХХҮГазартай хамтран 15 иргэнийг 7 хоног ажиллуулан мод тарих талбайг цэвэрлэх, модны нүх ухах ажлыг гүйцэтгүүлэх талаар төсөл бичиж, төслийн хүрээнд холбогдох бичиг баримт, материалыг бүрдүүлэн гүйцэтгэлийг хангуулан ажиллалаа.

2021 оны 3-р улирлын байдлаар 5 ойн мэргэжлийн байгууллага арчилгааны огтлолтоор 1249 м.куб, цэвэрлэгээний огтлолтоор 182 м.куб, цэвэрлэгээний ажлаар 130 м.куб модыг бэлтгэж, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 71,5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

“Ногоон Дархан” төслийн хүрээнд “Ногоон элчийн эзэд” шалгаруулах уралдааны болзлын дагуу тус газарт хүсэлт, материалаа ирүүлсэн 2 сургууль, 6 цэцэрлэг, 2 иргэний хүсэлтийн дагуу газар дээр танилцах, үнэлгээ өгөх ажлыг аймгийн БСУГазар, Сум дундын ойн ангитай хамтран 2021.10.20-ны өдөр зохион байгууллаа. Үнэлгээний дагуу шалгаруулах ажлын хэсгийг хуралдуулж, шагнаж урамшуулах байгууллагуудын танилцуулга хийх ажлыг бэлтгэж байна.

Унд ахуйн зориулалтаар гүний худаг гаргах хүсэлтээ ирүүлсэн 2 аж ахуйн нэгж 1 иргэний холбогдох материалыг судалж худаг гаргах зөвшөөрөл олгов.

“Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-ний төмөр толгойн төмрийн хүдрийн ил уурхайн 2021 оны ус ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулж ажиллаа.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар ашиглалтын 67, хайгуулын 7 нийт 73 тусгай зөвшөөрөлтэй ААНэгж байгаагаас алтны чиглэлээр 2021 онд үйл ажиллагаа явуулж буй 7 ААНэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн, 5 бичил уурхайн нөхөрлөлийн ахлагч нартай уулзаж ажиллалаа.

Хяналт шалгалтаар Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт орших Хүйтний голын Их ноён, Бага ноёны амууд /Эрэлийн ам, Цэхэрийн ам/-ын 2021 онд үерийн улмаас хүн хүрч чадахгүй байсан хэсгүүдээр явж уулын жижиг ам бүрийг нягтлан шалгаж ажиллалаа. Тус алслагдсан нутгуудад хууль бусаар техник байрлуулсан болон ашиг олох чиглэлээр очсон иргэд байхгүй, тайван байлаа. Тус амуудад эвдэрч эзэнгүй орхигдсон газрууд байгалийн жамаар хурдацтай нөхөн сэргээгдэж, зарим хэсгүүд нь хөрсөн бүрхэвч тогтон бүрэн нөхөн сэргээгдэж мэдэгдэхгүй болсон байна. Зарим эвдэрсэн газруудыг аймгийн эвдэрч эзэнгүй орхигдсон газрын мэдээллийн сангаас гаргах шаардлагатай талаар ажлын хэсгийн гишүүд ярилцан, санал нэгтгэйгээр 2022 онд газрын нэгдсэн сангийн мэдээллээс хасуулахаар холбогдох газарт уламжилахаар шийдвэрлэлээ.

1. Бичигт хад майнинг ХХК: MV-014989 дугаар бүхий “Бичигт хад” нэртэй тусгай зөвшөөрөлтэй /264.8 га/, алт олборлох үйл ажиллагаа явуулдаг ААНэгж, шаардагдах бичиг баримт бүрэн ба 2020 онд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 25 га талбайг актаар хүлээлгэн өгөөгүй байгаа ба 2021 онд 27 га талбайд техникийн,

дүйцүүлэн хамгааллаар 5 га талбайд техникийн нийт 32 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй. Одоогоор үйл ажиллагаа зогсонги байдалтай, нөхөн сэргээлтийн ажилдаа орохоор төлөвлөн бэлтгэл ажлаа ханган, техникийн засвар үйлчилгээгээ хийж байна. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээлт хийх талаар холбогдох албан бичгийг өгч ажиллалаа. /32 га/

2. Барилга орд ХХК: “Хүйтний гол” нэртэй MV-013331 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй /29.01 га/, алтны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ААНэгж, 2021 онд 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх ба дүйцүүлэн хамгааллаар 5 га газарт нийт 8 га талбайд техникийн нөхөнт сэргээлт хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үйл ажиллагаа усны гэрээ батлагдахыг хүлээн зогсонги байдалтай, олборлолт болон нөхөн сэргээлтийн ажилдаа орохоор төлөвлөн бэлтгэл ажлаа бүрэн хангасан байна. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээлт хийх талаар холбогдох албан бичгийг өгч ажиллалаа. /8 га/
3. Монгол газрын ховор илмент ХХК: 2020 онд Хөөсгөл ХХК-аас MV-013180 дугаар бүхий “Хуурай чулуутын дунд хэсэг” нэртэй тусгай зөвшөөрлийг /106.44 га/ шилжүүлэн авсан, цаашид алт болон үнэт метал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулах ба одоогийн байдлаар 2021 онд 0.8 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн ба нийт 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй. Хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдэхийг хүлээн зогсонги байдалтай байна. /3 га/
4. Манлай геологи хайгуул ХХК: 2020 онд Хааны харгуй ХХК-аас “Хуурай-1” нэртэй MV-021731 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг /31.71 га/ шилжүүлэн авсан, алтны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ААНэгж ба усны гэрээ батлагдахыг хүлээн зогсонги байдалтай байна. Одоогийн байдлаар 2021 онд 1.5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн ба нийт 10 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй. /10 га/
5. Чандмань метал орд ХХК: MV-015449 дугаар бүхий “Хар ямаат” нэртэй тусгай зөвшөөрөлтэй /119.3 га/, алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНэгж ба нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байна. 2021 онд нийт 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ. /10 га/
6. Бага таян ХХК: MV-000150 дугаар бүхий Хавчуу нэртэй тусгай зөвшөөрөлтэй /71.76 га/, алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНэгж ба техникийн нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байлаа. 2021 онд нийт 11 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийн хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. /11 га/
7. Хатан түшиг трөйд ХХК: MV-000396 дугаар бүхий Шаазгайт, Жалга 1, 2 нэртэй тусгай зөвшөөрөлтэй /54.53 га/, алт олборлох үйл ажиллагаа явуулдаг ААНэгж ба нөхөн сэргээлтийн ажил явагдаж байлаа. 2021 онд нийт 4 га талбайд техникийн, дүйцүүлэн хамгааллаар 2.5 га талбайд техникийн нийт 6.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр ажиллаж байна. /6.5 га/

Мөн Баялаг хайрханы өв, Баян газрын баялаг, Хайрханы хүчирхэг залуус, Мөнх баялагт хайрхан, Марал тамирын гол зэрэг нийт 5 бичил уурхайн нөхөрлүүдийн төлөөлөлүүдтэй уулзан нөхөн сэргээлтийн ажлыг 100% гүйцэтгэн, 2021.10.15-ны дотор Шарын гол сумын нөхөн сэргээлт хүлээн авах ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгч бэлэн болгохыг үүрэг болголоо.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 24 цагийн үйл ажиллагаатай 3 постууд нь Шарын гол, Хонгор сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ба 10 хоног тутамд постон үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг ээлж солилцоог хийн ажилласан. Постууд нь ойн сан, усан сан бүхий газарт нэвтрэх тээврийн хэрэгслүүд болон иргэдийг бүртгэлжүүлэн, хаврын хуурайшлын талаарх сэрэмжлүүлэг мэдээллийг

хүргэн, хүрээлэн байгаа орчны эсрэг аливаа төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

“Ногоон Дархан” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаанд оролцохоор бүртгүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг хийн 2021 оны 10 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд үзэсгэлэнгийн ажилд оролцож ажилласан.

2021 оны 10 дугаар сарын 28-30ны өдрүүдэд Улаанбаатар хотын “Мишээл экспо төв”-д 21-н аймгуудын хүрээнд зохион байгуулагдах “АйТиЭм” үзэсгэлэн худалдааны бэлтгэл ажлыг ханган холбогдох аж ахуй нэгж байгууллагуудтай уулзах ажлуудыг зохион байгуулж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Залуучууд театр, Дархан Өргөө кино театрын барилгад УСХ хийж, Залуучууд театрт 17, Дархан Өргөө кинотеатрт 12 заалттай Улсын ахлах байцаагчийн 2 албан шаардлагыг өгсөн.

1. МХЕГ-ын даргын баталсан 01/74 дугаартай Эрчим хүчний үйлдвэр, ААНБ-уудын техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, өвөлжилтийн бэлэн байдалд хийх удирдамжийн дагуу ДСЦТС ХК, ЦДҮС ТӨХК-ийн ТБС-т УСХ-ыг гүйцэтгэж, дүн танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн. УСХ-ын явцад ДДЦС ТӨХК-ийн эзэмшлийн улсын бүртгэлтэй Зуух №8, хурц уурын шугам, Дулаан Шарын гол ТӨХК-ийн зуухтай холбогдсон шугам хоолойд ээлжит, ДДЦС ТӨХК-ийн эзэмшлийн Зуух№6, өндөр даралтын халаагч 2а, 2б-д их засварын дараах ээлжит бус техникийн магадлал хийж, холбогдох акт, тэмдэглэлийг баталгаажуулсан.
2. Дархан-Уул аймгийн эрчим хүчний 8 аж ахуйн нэгж өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 268 ажил төлөвлөж гүйцэтгэснээс биелэлт 93.6 хувьтай байна. /ДДЦС ТӨХК 92 хувьтай, Дулаан Шарын гол ТӨХК 90 хувьтай, Дарханы Дулааны Сүлжээ ТӨХК 94.7 хувьтай, ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар 93 хувьтай, Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК 88 хувьтай, Эмт наран ОНӨҮГ 96 хувьтай, Дархан Мөнхийн илч ХХК 100 хувьтай, Орхондэлгэр ХХК 95 хувьтай/ Эрчим хүчийг төвлөрсөн байдлаар үйлдвэрлэдэг байгууллагуудын зуух, тоноглол, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал хангагдсан, горим ажиллагааны байдал хэвийн байна. Аймгийн эрчим хүчний 8 үйлдвэрт нийт 836 нэр төрлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхээс 2021 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар 78,4 хувийг бүрдүүлсэн байна.
3. МХЕГ-ын даргын баталсан 01/73 дугаартай удирдамжийн дагуу ЦДҮС ТӨХК-ийн ТБС, аймгийн ГХБХБГ-т УСХ-ыг хийж, холбогдох албан тушаалтнуудад мэргэжил аргагүйн зөвлөгөөг өгсөн, дүн, танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн. Цахилгаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхлэгч ДСЦТС ХХК-ийн ажилтнуудтай хамтран хяналтыг хийж, Дархан сумын нутаг дэвсгэрт хамгаалалтын зурвасын 57 зөрчлийг арилгуулж, хэрэглэгчийг болзошгүй ослоос сэргийлж, ажиллалаа.
4. ЦДҮС ТӨХК, ДСЦТС ХК-тай хамтран хамгаалалтын зурвасын зөрчилтэй 47 хэрэглэгчид мэдэгдэл хүргүүлж, хяналтад хамрагдсан 17 ААНБ-ын удирдах болон ИТА-уудад Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүллээ. Цахилгааны мэргэжлийн ажилтангүй хэрэглэгчийн 6кВ ба түүнээс дээш хүчдлийн түвшинтэй цахилгаан дамжуулах шугам сүлжээ, тоноглолын ашиглалт, аюулгүй ажиллагааны байдал нь зөвхөн хангагч байгууллагын хяналтаар зохицуулагдаж байна. Хамгаалалтын зурвасын зөрчилтэй цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн цахилгааны хэрэглээг хязгаарлах хугацаатай мэдэгдлийг хүргүүлж хэрэгжүүлэх, эрчим хүчээр хангах гэрээнд болзошгүй эрсдлийг тусгах чиглэлийг баримтлан ажиллах шаардлагатай байна.
5. МХЕГ-ын даргын баталсан 10/75 дугаартай удирдамжийн дагуу Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт бага хүчин чадлын зуухны үйлдвэрлэл, угсралтын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд УСХ хийж, дүн танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн. 1 иргэн хамрагдсан. Тус иргэний зохион бүтээсэн Ихэр дөл зуух нь 80-500кв талбайг халаах хүчин чадалтай, халаах талбайн хэмжээнээс хамааруулж 11 төрлийн хүчин чадалтайг, дан ба хос хийцээр үйлдвэрлэдэг. Монгол улсын Оюуны өмчийн газраас 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Нүүрс хорт хийн нэгдлийг хамт шатаах усан халаалтын зуухны бүтээц, ажиллагааны горим” нэртэй Ашигтай загварын гэрчилгээ авсан. 2019 онд Дархан сумын Сум хөгжүүлэх сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч гарааны бизнесээ эхэлсэн. Зуух үйлдвэрлэх баг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй.
6. “Ихэр дөл” зуухыг Стандарт, хэмжилзүйн газрын тохирлын үнэлгээнд хамруулаагүй нь зөрчилтэй байна. Шалгалтын явцад Дархан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт айл өрхийн суурьшлын бүсэд зуух үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж байсныг нүүлгэн, үйлдвэрлэлийн бүсэд шилжүүлсэн. Зуух үйлдвэрлэж буй ажилтнуудад холбогдох хууль, дүрэм, журам, цаашид анхаарах асуудлаар мэргэжил аргагүйн зөвлөгөө өгсөн. Аж ахуйн

үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.5.дахь заалтад “зуух, даралтат сав, шугам хоолойн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх” гэж өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/18 дугаартай удирдамжийн дагуу хууль бусаар байгалийн нөөц баялгын ашиглалтын байдалд Хонгор, Шарын гол сумдын ой бүхий нутагт хяналт шалгалт хийж, түлшний мод бэлтгэн тээвэрлэж буй 4 иргэнийг шалгасан. Шалгалтаар хууль бус зөрчил илрээгүй. Шалгалт үргэлжилж байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/10 дугаартай удирдамжийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 11 ААН, 5 бичил уурхайн нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Хяналтаар бичиг баримтын бүрдэл дутуу 1 ААН-ийн үйл ажиллагааг илэрсэн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд улсын байцаагчийн актаар зогсоогоод байна. Бусад ААН, нөхөрлөлүүдийн холбогдох бичиг баримтын бүрдэл бүрэн, нөхөн сэргээлтээ хийж, хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Аймгийн хэмжээнд урьдчилсан байдлаар 53.3 га талбайд техникийн, 7.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй, усны эх үүсвэрийн онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх, батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, зэрлэг амьтнаас болгоомжилж, аюулгүй байдлаа хангаж ажиллах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж ажиллах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

1. МХЕГ-ын даргын баталсан 01/57 дугаартай удирдамжийн дагуу соёлын төвийн барилга байгууламжид хамтарсан шалгалтыг хийж 6 барилгын ашиглагч, 1 угсралтын ажлын гүйцэтгэгчийг хамрууллаа. Өөрийн барилгатай 5 ААНБ-ын эрсдлийг барилгын ашиглалтыг шалгах хяналтын хуудсаар үнэлэхэд тус бүр бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Музей номын сангийн цогцолборын барилгын угсралтыг гүйцэтгэж байгаа Вокм ХХК-ийн үйл ажиллагааг шалгаж, зөвөлгөө өгсөн.
2. МХЕГ-ын даргын баталсан 01/38, 01/97 дугаартай удирдамжуудын дагуу шинээр баригдаж байгаа 10 барилгын гүйцэтгэгч ААН-ийг хамруулан шалгалтыг хийж, зөвөлгөө өгч, МХЕГ-аас боловсруулсан зөвлөмжийг хүргүүлсэн.
3. Дархан сумын ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтээр Дархан сумын 6,9,10,11,12,13,14,16,15 дугаар багийн барилгын ашиглалтын төлөв байдал, зураг төсөл, холбогдох баримт бичигт хот байгуулалтын хяналтын улсын байцаагчтай хамтран шалгалт хийж, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа тухай дүгнэлт гаргаж хүргүүлсэн.
4. Өргөө багт баригдсан 100 хүүхдийн цэцэрлэг, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд хийгдсэн төмөр замын барилга, байгууламж, алсыг харагчийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, зураг, төсөл, баримт бичиг, угсралтын ажлын гүйцэтгэлтэй танилцаж, ашиглалтад хүлээн авах санал хүргүүлсэн.
5. Хүсэлтийн дагуу Дархан сумын 24-р цэцэрлэгийн барилгын ханын цууралтыг үзэж, албан бичгээр хариу өглөө.
6. МХЕГ-ын даргын баталсан 01/38 тоот удирдамжийн дагуу. Дархан сумын 14 дүгээр байрны дээврийн ашиглалтын төлөв байдалд үзлэг хийж дүгнэлт гарган хүргүүлсэн.
1. Дархан-Уул аймгийн 5 дугаар цэцэрлэгийн барилгад үзлэг шалгалт хийсэн. Барилгын ашиглалтын төлөв байдлын тухай дүгнэлт гарган хүргүүлсэн.
2. МХЕГ-ын даргын баталсан 01/38 тоот удирдамжийн дагуу. Дархан сумын 11 дүгээр багт Хунт улз ХХК-ын барьж байгаа 108 айлын орон сууц, Баян бридж ХХК-ийн барьж байгаа 216 айлын орон сууц, Хэрлэн зураглал ХХК-ийн барьж байгаа 116 айлын орон сууц, Говь яшилт ХХК-ийн барьж орон сууцны барилга, Боршоон ундраа ХХК-ийн барьж байгаа ХӨгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга, Дархан сумын 14 дүгээр байрны дээврийн ашиглалтын төлөв байдалд үзлэг хийж 1 дүгнэлт гарган хүргүүлсэн.

Авто зам: Дархан-Шарын гол чиглэлийн 22.3 км авто замын барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа Анандын зам ХХК-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд 5 хэсэгт кемп байгуулж, хөрс хуулалтын ажил эхэлсэн байна. ОДНД ХХК-ийн засвар шинэчлэлт хийж байгаа Цагдаагийн

уулзварт газар чөлөөлөлт болон зургийн өөрчлөлтийн асуудал байгааг Аймгийн ЗДТГ-т уламжилсан, одоогоор шийдвэрлээгүй байна.

Автотээвэр: Тэспетролиум ХХК, Сод монгол ХХК, НИК ХХК-ийн Дархан салбарын нийт 14 аюултай ачааны тээврийн хэрэгсэлийн техникийн бэлэн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, НИК ХХК-ийн Дархан салбарт 5 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

МХЕГ-ын 01/54 тоот удирдамжийн дагуу Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зам угсралт, арчлалт засварын 2 байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийж, 74 зөрчил илрүүлж, 44 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлээд байна.

ГХБХБГ-тай хамтран барилга угсралтын 3 байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийж, 11 зөрчлийг арилгуулахаар тэмдэглэлээр үүрэг болгов.

МХЕГ-ын даргын баталсан 01/68 дугаартай Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу 4 ААНБ-т тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүр ашиглаж буй болон тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан зэрэгт хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар зөрчил илрээгүй. Нийт 8 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

МХЕГ-ын 2021 оны 01/94 дугаартай “Нялх балчир хүүхдийн хүнсний найрлага, сав баглаа боодол, шошгод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжтай шалгалтанд 3 ААН хамрагдаж нийт 12 зөрчил илрүүлж газар дээр нь 7 зөрчлийг арилгуулав.

МХЕГ-ын 2021 оны 01/20 дугаартай “Зах зээлд нийлүүлж буй малын эм, тэжээлийн нэмэлтийн улсын бүртгэл, шинжилгээ, баталгаажилт, жороор олголтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх” удирдамжийн хүрээнд 2 аж ахуйн нэгжийн мал амьтны эмийн санг хамруулж, холбогдох бичиг баримтанд шалгалт хийв. Шалгалтаар нийт 6 зөрчил илрүүлж, 66.6 хувийг шалгалтын явцад арилгуулан, 1 ААНБ-д 3 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгөв.

МХЕГ-ын 2021 оны 01/146 дугаартай “Мал эмнэлгийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх шалгалт хийх” удирдамжийн хүрээнд аймгийн МЭГ, 3 сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлэг үйлчилгэний 6 ААН нийт 10 объектыг хамруулан шалгалт хийв. Шалгалтын явцад 3 зөрчил илрүүлж, газар дээр нь арилгуулан, 5 төрлийн 8 ширхэг гарын авлага тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ЦАГ УУР:

10 дугаар сарын 20-ны агаарын температурын дунджийг олон жилийн дундажтай харьцуулахад Дархан суманд 2 градусаар дулаан, Шарын гол, Хонгор, Орхон сумдад олон жилийн дунджийн орчим. Хөрсний температурын дунджийг олон жилийн дундажтай харьцуулахад Дархан суманд 3 градусаар дулаан, Орхон, Шарын гол, Хонгор сумдад дунджийн орчим байлаа.

Хүснэгт 1. Цаг агаарын мэдээлэл

Сумдын нэрс	Агаарын температур, (градус)			Хөрсний температур, (градус)			Хур тунадас (мм)		Салхи (м/с)	
	Дундаж	Үнэмлэхүй их	Үнэмлэхүй бага	Дундаж	Үнэмлэхүй их	Үнэмлэхүй бага	Хэмжээ, мм	Өдрийн тоо	Их хурд м/с	10 м/с-ээс дээш салхитай өдрийн тоо
Дархан	3.8	17.1	-9.0	6.0	33.7	-9.9	16.2	6	14	3

Шарын гол	2.0	16.7	-13.5	3.6	32.5	-13.5	14.3	6	14	5
Орхон	2.1	16.5	-10.8	3.8	30.4	-12.0	20.8	4	12	6
Хонгор	2.1	18.0	-13.6	4.1	34.6	-14.0	24.8	5	14	4

Хур тунадас:

Дархан, Шарын гол сумдад олон жилийн дунджийн орчим, Орхон, Хонгор сумдад олон жилийн дунджаас ахиу хур тунадас унажээ.

Салхи:

10 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгаар салхины их хурд 12-14 м/с хүрсэн. 10 м/с дээш салхитай өдөр бүх сумдад тус бүр 3-6 өдөр ажиглагдсан.

Хүснэгт 1. Цаг агаарын мэдээлэл

Сумдын нэрс	Агаарын температур, (градус)			Хөрсний температур, (градус)			Хур тунадас (мм)		Салхи (м/с)	
	Дундаж	Үнэмлэхүй их	Үнэмлэхүй бага	Дундаж	Үнэмлэхүй их	Үнэмлэхүй бага	Хэмжээ, мм	Өдрийн тоо	Их хурд м/с	10 м/с-ээс дээш салхитай өдрийн тоо
Дархан	3.8	17.1	-9.0	6.0	33.7	-9.9	16.2	6	14	3
Шарын гол	2.0	16.7	-13.5	3.6	32.5	-13.5	14.3	6	14	5
Орхон	2.1	16.5	-10.8	3.8	30.4	-12.0	20.8	4	12	6
Хонгор	2.1	18.0	-13.6	4.1	34.6	-14.0	24.8	5	14	4

Агаарын чанар: Дархан, Шарын гол сумдад агаар дахь хүхэрлэг хийн /SO₂/ болон азотын давхар ислийн /NO₂/ дундаж агууламж агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давж бохирдсон тохиолдолгүй. 10 дугаар сарын 01-21 ний байдлаар PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламж 0.078мг/м³ MNS4585:2016 стандартын хоногийн дундаж хүлцэх агууламжаас 1 удаа давж бохирдсон ба Агаарын чанарын индексийн үнэлгээгээр “ХЭВИЙН” түвшинд, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр агаарын чанарын стандарт шаардлага хангах боловч зарим хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай байсан.

Гадаргын усны хяналт-шинжилгээ: Гадаргын усны химийн шинжилгээний сорьцыг 09 дүгээр сарын 09-нд хөтөлбөрийн дагуу Хараа-Дархан дээд, Хараа-Дархан доод, Шарын гол-Автозамын гүүр, Шарын гол-Усны харуул, Хүйтэн-Шарын гол усны харуул гэсэн хяналтын 5 цэгээс дээж авч усны химийн шинжилгээгээр бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

Усны химийн задлан шинжилгээний дүнгээр:

Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир ус нийлснээс доош Бүрэн толгойн орчмоос авсан дээжинд голын усанд ууссан хүчилтөрөгч /O₂/-ийн агууламж алдагдаагүй байна.

Голын усны бохирдлыг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг хялбар исэлдэх органик бохирдуулагч буюу биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч БХХ₅-ийн агууламжийн явцыг харуулав.

Голын усны бохирдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг гадаргын усны чанарын MNS4586:98 стандарттай харьцуулахад Хараа-Дархан дээд, Хараа-Дархан доод, Шарын гол-Автозамын

гүүр, Шарын гол-Усны харуул, Хүйтэн-Шарын голд ууссан O₂, BXX₅, ПИЧ, NH₄, NO₂,P үзүүлэлтүүд тус тус давсан тохиолдолгүй байна.

2021 оны хөрсний намрын явуул судалгааны чийгийн нөөцийг тодрхойлсон дүнгээр уриншилсан болон гуурс, төмс, бэлчээрийн талбайн 0-20 см, 0-50 см, 0-100 см гүнүүдэд бүх талбайд 67-135% буюу хангалттай чийгтэй байна.

Ус судлалын Хараа гол, Хүйтэний гол, Шарын голуудын усны түвшин өмнөх сараас аажмаар бууж, 10 дугаар сарын 21-ний байдлаар ОЖД-аас Хараа гол 15 см-их, Шарын гол дунджийн орчим, Хүйтэний гол ОЖД-аас 13 см их түвшинд байна. Ус судлалын Хараа голын хамгийн их түвшин 156 см, Шарын голын хамгийн их түвшин 235 см, Хүйтэний голын хамгийн их түвшин 259 см, ОЖД-аас 5-13 см их түвшинд байна. Голуудын усны түвшин тогтворжиж ОЖД-ийн орчим, хэлбэлзэл багатай тогтвортой байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Хуулийн этгээд татан буулгах тухай” 71 дүгээр тогтоолыг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг татан буугдсан “Дарханбизнес инкубатор” орон нутгийн өмчит ААТҮГ-ын 22,208,355.00 төгрөгийн балансын үнэ, 21,182,622.01 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багийн нутаг дэвсгэрт 2019 онд Дархан сумын 12 дугаар иргэн Гүррагчаа овогтой Батнасангийн хандиваар бий болсон 10,222,000.00 төгрөгийн үнэ бүхий 11 ширхэг гэрлийн шонг Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын санхүүгийн тайланд бүртгэх тогтоолыг батлуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 105, 2021 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр нээлттэй дуудлага худалдаагаар аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 2 тээврийн хэрэгслийг 1.6 сая төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 8,251.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,482.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 418.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 135.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Япон улсын засгийн газрын өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих /142.361 доллар/ 405.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, **нийт 12,694.2 сая** төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй **58** төсөл арга хэмжээний худалдан авалтыг **95 хувийн гүйцэтгэлтэй, 252.8 сая** төгрөгийн хэмнэлт үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

Тендер нь зарлагдсан 710.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, гэрээ байгуулах эрх олгосон 9,681.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53, хүчингүй болж дахин зарлагдах 1,896.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ тус тус байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Барилга хот байгуулалтын яамнаас 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 1,060,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, Соёлын яамнаас 5,000,0 төгрөгийн төсөвт өртөгтэй, 1, Зам тээвэр хөгжлийн яамнаас 41,044.5

сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4 төсөл, арга хэмжээ, Эрүүл мэндийн яамнаас 486.0 сая төгрөгийн 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Биеийн тамир спортын хорооноос 3,500.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй 1, **НИЙТ 54,797.5** сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, **18 төсөл, арга хэмжээ** тус тус эрх шилжигдэн ирснийг **100 хувийн гүйцэтгэлтэй, 1,384.8 сая** төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

Үнэлгээний шатанд 1,500,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, гэрээ байгуулах эрх олгосон 53,297.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл арга хэмжээ тус тус байна.

ХОНГОР СУМ:

Сумын ЗДТГ болон төсвийн байгууллагууд давхардсан тоогоор 2542 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлж, багийн тодорхойлолт, маягт 806 иргэн, төрийн үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл 1110 иргэнд өгч, нийгмийн халамжийн үйлчилгээ 171, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд- 421, цагдаагийн байгууллага-34 иргэнд, тус тус үйлчиллээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газарт 29 албан бичиг, газрын 24 өргөдөл, бусад 7 өргөдөл ирснийг хүлээн авч шийдвэрлэлээ.

2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын товчоогоор нийт 211 иргэн орж нийт 22 иргэн үзлэгт тэнцэж, 1 иргэн өвчлөж 21 иргэн цэргийн албанд татагдаад байна.

Дархан–Уул аймагт “Төвийн бүсийн түншлэл-2021” “Хөдөлмөрийн яармаг”, “Намрын ногоон өдрүүд”, Их хотын баяр үзэсгэлэн худалдаа 2021 оны 10 сарын 14-нөөс 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдаж сумаас сүү, цагаан идээний төрлөөр 2 иргэн, хүнсний ногоо нөөшилсөн бүтээгдэхүүнээр 1 иргэн, бусад төрлөөр 1 нийт 4 иргэн амжилттай оролцоод байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 10-ний 01А/248 дугаартай захирамжийн хэрэгжилтийг ханган “Цэмцгэр–Дархан” аян, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэн суманд Бүх нийтийн мод тарих өдрийг 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж төр, төсвийн 6 байгууллагын 210 албан хаагч 200 ширхэг модыг тарьсан байна.

Аймгийн 60 жилийн ойг тохиолдуулан “Дархан-60” жил тэмдэгээр сумын 30 иргэн шагнагдсан байна.

Татварын орлогын 10 дугаар сарын орлогын төлөвлөгөө 446.9 сая, гүйцэтгэл 892.8 сая. 199.7 хувь биелэлттэй байна. 10-р сарын 25 ны байдлаар тухайн сарын татварын орлогын төлөвлөгөө 54.6 сая гүйцэтгэл 51.7 сая 94.8 хувь .Өссөн дүнгээр төлөвлөгөө 781 сая, гүйцэтгэл 944.5 сая 120.9 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн хөгжлийн сан- 2021 оны зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 112.0 сая төгрөгөөс гүйцэтгэл нь 2021.10.15-ны байдлаар 111,146.0мян/төгрөг буюу 99.2%-тай. Нийт эх үүсвэрээс 42,2%-тай байна.Өмнөх оны харилцахын үлдэгдэл 18.394.02.28 мян/төгрөг байна. Нийт үлдэгдэл 129.540.0 мян/ төгрөг байна.

2021 онд сумын хэмжээнд давхардсан тоогоор нийт 295.9 мянган толгой малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний календарьчилсан төлөвлөгөөний дагуу тарилга, үйлчилгээг явуулж, боом, цусан

халдварт, дуут хавдар, хурга ишигний шөвөг яр, дотрын халдварт хордлого, нохойн галзуу, гахайн мялзан, цусан халдварт-иж балнад, бруцеллёз зэрэг 10 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх тарилгад давхардсан тоогоор 267.0 мянган толгой малыг хамруулж гүйцэтгэл 90,2 %-тай байна. Намрын бруцеллёзын тарилганд 8,8 мянган үхэр, 65,0 мянган бог мал, нийт 73,8 мянган толгой мал хамрагдахаас 100%-тай буюу 73,8 мянган толгой мал хамрагдаад байна. Томуугийн вакцинд 4700 адуу, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1300 нохой хамрагдаж намрын тарилгын ажил дуусаад байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 05 дугаар тогтоолоор мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй 3 ААН нь мал, амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэн ажиллаж, туулгалтанд 185,2 мянган толгой мал хамрагдахаас 116,4 мянган толгой мал хамрагдаж 62,8 %, боловсруулалтанд 182,8 мянган толгой мал хамрагдахаас 66,8 мянган толгой мал хамрагдаж 36,4 % тай, угаалганд 175,8 мянган толгой мал хамрагдахаас 164,9 мянган толгой мал хамрагдаж 93,8 %-ийн гүйцэтгэлтэй байна. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын ажил 11 сар хүртэл үргэлжилнэ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 803 малчин, мал бүхий иргэнтэй 8806 га газарт хадлан хадах зөвшөөрөл олгосон. Нийт 27000 тн хадлан бэлтгэхээс одоогийн байдлаар 26.700 тн хадлан бэлтгэсэн. Биелэлт 98,8% тай байна.

Малчин, мал бүхий 96 иргэдээс ноосны урамшуулалын материалыг хүлээн авч хүнс хөдөө аж ахуйн газарт албан тоотор хүргүүлээ.

Хүүхдийн гэр бүлийн эрсдэлийг тодорхойлж, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээнд 30 өрхийг хамрууллаа.

Охидын эрхийг хамгаалах өдөр Хонгор сумын 14 дүгээр сургууль, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран хамтран зохион байгууллаа Үйл ажиллагаанд хүрээнд сургуулийн эмэгтэй сурагчдад “Олон улсын охидын өдөр”-т зориулан заавар зөвлөмжийг тарааж, мэдээллийн самбарт байршууллаа.

Дархан-Уул аймгийн 60 жилийн ойд зориулан Бүтэн өнчин хүүхдүүд хичээлийн хэрэгсэл худалдан авах 100.000 төгрөгний эрхийн бичиг, 1,2,3 дугаар багт оршин суудаг нийт 9 бүтэн өнчин хүүхдээс Хонгор сумд байгаа 5 хүүхдэд эрхийн бичгийг гардуулна өгсөн.

Сумын ЭМТөвд амбулаторийн үзлэгт нийт 421 иргэн хамрагдсанаас урьдчилан сэргийлэхэд- 207, идэвхтэй хяналтын үзлэгт- 49, өвчний учир- 31, гэрийн эргэлтийн үзлэг- 133 иргэн хамрагдаж, томуугийн өвчлөл- 5, нийт дуудлага- 11, хэвтэн эмчлүүлсэн иргэн-8, жирэмсний хяналтад байгаа иргэн-50 иргэнд үйлчилгээ үзүүлж, Энэ сард ЭМС-н 388-р тушаалын дагуу яаралтай тусламийн эм тариа болон ороох боох материалаар 34 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 89%-тай байна. Ковид-19 дархлаажуулалтанд нийт 7988 1-р тун 3607, 2-р 3333 тун, 3-р тун 1048 хамрагдсан. /10.18-10.23 дуустал нийт 408 иргэнийг Ковид-19-н дархлаажуулалтанд хамруулав. 2-р тун-4, 3-р тун-404/

Товлолт вакцинд нийт 59 хүүхэд, томуугийн дархлаажуулалтад 400 хүүхэд 100% хамрагдлаа.

Энэ сард нийт 7 анги буюу 170 сурагч цахимаар хичээллэн тусгаарлалт буюу гэрийн ажиглалтанд 7 хоногоор шилжсэн. Мөн ковидын халдвараар 1 багш, 10 сурагч,

3 ажилтан шинээр өвчлөж ойрын хавьтлын тусгаарлалтанд 5 ажилтан байсан. Сахуу татрангын вакцинд хамрагдах 2 болон 15 настай 53 хүүхдийн судалгааг гаргаж эрүүл мэндийн төвд хүргүүллээ.

Сургуульд суурилсан үнэлгээний төвөөс 10 дугаар сарын 18-наас 10 дугаар сарын 27-ны хооронд сургуулийн 2-12 дугаар ангийн 334 сурагчдаас судлагдахуун тус бүрээр шалгалт авч ажиллаа.

2021 оны 09 дүгээр сарын 30-ний өдрөөс 10 сарын 01-ний өдрийн хооронд 2 хоногийн хугацаанд Улаанбаатар хотод 7 соёл урлагын байгууллагаар зочилон байгууллага бүрээс ажилчид өөрийн мэргэжлийн дагуу ажлуудтай танилцан шинэ санаа шилдэг шийдэл танин мэдэхүйн сэтгэл ханамжтай ажиллаж ирсэн.

1. БЗДын Жанжин клуб,
2. Байгалын түүхийн музей,
3. Монголын үндэсний музей,
4. Хөгжим бүжгийн сургууль,
5. Хүүхдийн үндэсний номийн сан,
6. Монголлын уран зургын Галерей,
7. Үлэг гүрвэлийн музей зэрэг багууллагаар орж байгууллага бүрээс сургалт авч ажиллаа.

Гэмт хэргийн шинжтэй 2, зөрчлийн шинжтэй-1, нийт 14 дуудлага ирсэн ба бэлэн бус торгуулийн машинаар 380.000 төгрөгийн торгуулийг ногдуулж, хариуцлага тооцлоо.

ОРХОН СУМ

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргад аймгийн хэлтэс агентлагууд, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд, бусад аймаг сумдаас нийт 44 албан бичиг ирүүлснээс хугацаатай болон хариутай албан бичиг 13 ирсэн байна. Үүнээс 10 албан бичгийн хариу хүргэгдэж, 3 албан бичгийн хариу хугацаа болоогүй хүлээгдэж байна.

Сумын Засаг даргаас 18 албан бичиг, ЗДТГ-ын даргаас 4 албан бичиг нийт 22 албан бичиг явуулсан.

Нэг. Иргэний бүртгэл мэдээлэл, өргөдөл гомдол барагдуулах чиглэлээр:

Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 66 иргэнд үзүүллээ. Үүнд:

-Төрсний бүртгэл	6 иргэн
-Нас барсны бүртгэл	1 иргэн
-Шилжилт хөдөлгөөний бүртгэл	6 иргэн
-Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл бүртгэл	3 иргэн
-Иргэний үнэмлэхний олголтын бүртгэл	15 иргэн
-Мэдээлэл зөвлөгөө өгсөн	35 иргэн тус тус байна.

Тайлант хугацаанд 121,8 сая төгрөгийн 103 гүйлгээг хийснээс дансны нэр зөрүүтэй буцсан 1 гүйлгээ байсны нэрийг засаж дахин шилжүүлсэн.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын 3 дугаар улирлын тайланг 112 ААН байгууллага ирүүлэхээс 97 ААН тайлангаа цахимаар ирүүлж 86.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант сарын татварын орлого 8.4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 7.9 сая төгрөг буюу 94.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Өссөн дүнгээр буюу 10 сарын 20-ны өдрийн гүйцэтгэлээр 128.6 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 132.6 сая төгрөгийн орлого төвлөрч 103.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайд Эрүүл мэндийн сайдын А/292, А/525 дугаар тушаалын дагуу бэлтгэл ажил хангагдаж 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 20 бүлгийн хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Коронавирусээс урьдчилан сэргийлж сурагчдын бөөгнөрөлийг багасгахын тулд “Гэр Сургууль, Сургууль Гэр” гэсэн маршрутыг хэрэгжүүлж анги удирдсан багш нар өдөр бүр сурагчдын ирсэн, гэртээ харьсан цагийн бүртгэлийг эцэг, эхтэй нь холбогдон тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Томуугийн вакцинд хамрагдах 201 сурагч байгаагаас 197 сурагч вакцинжуулалтад хамрагдсан.

А/292, А/525 дугаар тушаалын 4.1 дэх заалтын дагуу ковидоос урьдчилан сэргийлэх ажлын хэсэг томилон сургачид болон албан хаагчдын амны хаалтыг зүүлгэн сургууль руу нэвтрүүлж биеийн халууныг хэмжин QR кодыг уншуулан тэмдэглэл хөтлүүлээ.

Орхон сумын Насан туршийн боловсролын нэгжээс Дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан “Бүгдээрээ хуримтлуулъя” аяны хүрээнд Хаан банктай хамтран “Хуримтлалын ач холбогдол ба хүүхдийн хадгаламж” сэдэвт сургалтыг 8 дугаар ангийн 21 сурагчд хамрагдан зохион байгуулагдсан. Сургалтад амжилттай оролцсон сурагчдыг Хаан банкны зүгээс шагнаж урамшууллаа.

Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан “Сурагчдын оношлогоо шалгалт”-нд түүврээр 2-9 дүгээр ангийн 171 сурагч 24 судлагдахуунаар хамрагдлаа.

Аймгийн Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан “Санхүүгийн мэдлэг олгох” сургалтад ахлах ангийн 21 сурагч хамрагдлаа.

Аймгийн сургалтын менежерүүдийн цахим сургалтад 2 удирдах ажилтан, бага ангийн багшийн математикийн чадварыг хөгжүүлэх арга зүйн сургалтанд бага ангийн 10 багш, математикийн хичээлийн заах арга нэгдлийн сургалтад 1 багш тус тус хамрагдсан.

Тайлант сард 1110 хүүхэд хүлээн төлөвлөгөөтэйгөөс танхимын сургалтаар 842 хүүхэд, зайн сургалтаар давхардсан тоогоор 324 хүүхэд хүлээн авч 75.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Коронавируст халдвараар өвдсөн 2 хүүхэд байна. Ойрын хавьтал болж тусгаарлалтанд орсон 24 хүүхэд байна.

Хүүхдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлж өглөө бүр ам зайлах сода, давсны уусмалыг бэлтгэн өгч ажиллаж байна. 4 бүлгийн 64 хүүхдэд 4 удаагийн хэрэглээний витаминь олгож ажиллалаа.

Цэцэрлэгийн заах аргын нэгдлээс зохион байгуулсан “Сургалтын хөтөлбөр-Хүүхдийн үнэлгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж 6 багш хамрагдсан.

БСУГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалт, зөвөлгөөнд 4 багш хамрагдсан. БСУГ-аас зохион байгуулсан “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн танилцуулга”-д ахлах багш А.Эрдэнэзул оролцсон.

Байгууллага анги танхимын цэвэрлэгээ ариутгалд угаалгын шингэн бодис, аяга таваг угаагч, гарын шингэн саван, гар ариутгагч, 1 удаагийн амны хаалт, 1 удаагийн малгай, бээлий, улавч, резинэн бээлий 12 хос, спиртэн ханд, цэвэрлэгээний арчих материал 15 ширхэгийг тус тус олгож ажилласан. Үүнд: 250.8 мянган төгрөг зарцууллаа.

Хүүхэд, багш, ажилтны өвчлөлийн талаар цэцэрлэгийн эрсдэлийн баг тандалт судалгааг хийн ажиллаж байна. Коронавируст халдвараар 4 ажилтан өвчилсөн. Одоогоор гэрийн эмчилгээнд 3 ажилтан байна.

Тайлант сард 30 хүүхэд, дотор 140 хүн нийт 170 хүнийг хэвтүүлэн эмчилж зонхилон тохиолдох өвчний эмнэл зүйн удирдамж, стандартын дагуу эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Стационарт хэвтэн эмчлүүлэгчдэд сувилахуйн ор засалт 170, давхардсан тоогоор булчин тариа 820, дусал тариа 208, судас тариа 186, арьсан дор тарилга 69 арьсан дотор тарилга 10, уян зүү 2, шарлага 4, амин үзүүлэлт 196 иргэнд тус тус үйлчилсэн.

Амбулаториор давхардсан тоогоор булчин тариа 169, дусал тариа 93, судас тариа 102, боолт 35 удаа, уян зүү 2, шарлага 3, арьсан дор тарилга 45, арьсан дотор тарилга 8 нийт 190 иргэнд үйлчилсэн.

Одоо байгаа жирэмсэн эх 18 байна. Үүнээс: Хяналтанд шинээр орсон 1 эх,

0-3 сартай 1 эх тус тус байна. Аймагт 1 эх төрсөн.

1 удаагийн комбинзон 36 ширхэг, нэг удаагийн халад 460 ширхэг, нэг удаагийн бээлий 100 ширхэг, 1 удаагийн амны хаалт 5200 ширхэг, 1 удаагийн шүүлтүүртэй маск /N 95/ 80 ширхэг, нүүрний хаалт 120 ширхэг, 1 удаагийн улавч 300 ширхэг, нүдний шил 45 ширхэг, усны гутал 4 ширхэг, 1 удаагийн малгай 180 ширхэг, Жавелин /1500 ш/ 5фл, Саннитол /55.0-65,0/ 28 фл, спирт /70% / 5 литр, спирт /96%/ 1 литр тус тус байна.

Түргэвчилсэн тест 150 ширхэг, PCR шинжилгээний оношлуур 550 ширхэг байна.

Ковид -19 өвчний эсрэг Файзер вакцины 3 дугаар тунг 310 хүн, 2 дугаар тунг 5 хүнд тус тус хийсэн. Вероцелл вакцины 2 дугаар тунг 2 хүнд хийсэн.

Ковидоос урьдчилан сэргийлэх зөвлөмж 439 хүнд өгч үйлчилсэн.

Ковидын түргэвчилсэн оношлуураар шинжилгээ 702 хүнд хийхэд 210 хүн эерэг гарсан. PCR шинжилгээ 5 хүнээс авч аймгийн Эрүүл мэндийн газарт хүргэхэд 5 иргэний шинжилгээ эерэг гарч тархвар судалгааг аван аймгийн Эрүүл мэндийн газарт хүргэсэн хүргэсэн.

Нийт ойрын хавьтал 472 хүн гэрээр хянагдаж 420 хүн хяналтаас гарч одоогоор 52 хүн хяналтанд байна.

Тайлант хугацаанд ковидоор нийт 210 хүн өвдөж аймагт 6 хүн эмчлэгдэн, суманд 204 хүн хэвтэн эмчлүүлсэн. Одоо суманд 37 хүн хэвтэн эмчлүүлж байна.

Тайлант сард Эрүүл мэндийн даатгалд 8 малчин иргэн хамрагдсан. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 10 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, сайн дурын даатгалд хамрагдсан 5 иргэний даатгалын гэрээг сунган ажиллалаа. Өндөр настны тэтгэвэрт шинээр 3 иргэн тэтгэвэр тогтоолгосон.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудлаар:

- Цалинтай ээжийн тэтгэмж	147 иргэн
- Жирэмсэн эхийн тэтгэмж	8 иргэн
- Ахмад настан асаргааны тэтгэмж	46 иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа	23 иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа	12 иргэн
- Өндөр насны тэтгэвэр	6 иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	42 иргэн
- Тэжээгчээ алдсаны тэтгэмж	24 иргэн
- Хүнсний эрхийн бичиг	34 өрх тус тус авч байна.

Тайлант сард хүүхдийн мөнгөний асуудлаар 1 иргэний өргөдлийг хүлээн авч нөхцөл байдлын үнэлгээ хийж холбогдох материалыг бүрдүүлэн Гэр бүл Хүүхэд, Залуучууд хөгжлийн газарт хүргүүлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хуулиар 8 иргэнд зөвлөмж зөвлөгөөг өгч ажиллаа.

Тайлант сард гэр бүл хүүхэд хамгааллын Хамтарсан баг 1 удаа хуралдаж, 1 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу хүүхдийн мөнгийг төрсөн эцэгт нь олгуулах шийдвэр гаргасан.

Жендерийн статистик мэдээллийг бэлтгэн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршууллаа.

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын утасны жагсаалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвлөмж гэсэн 2 төрлөөр тус бүр 30 ширхэг боршурыг бэлтгэн багийн байр болон ЗДТГ-т байршууллаа.

2021-2022 онд 523 өрх, 2 ААН-д 49893 мал өвөлжиж, хаваржина. Үүнд: Тэмээ 27, адуу 2853, үхэр 12209, хонь 16846, ямаа 17958, хээлтэгч мал 22811, нэг настай мал 14530 тус тус байна.

Өөр аймаг сумын нутагт 33 өрхийн 5235 мал отроор өвөлжиж, хаваржихаар байгаа бөгөөд малчин өрхийн бэлтгэл 95.4 хувь, мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангагдаж 95.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ онд 8179 эм хонь, 8484 эм ямаа хээлтүүлэгт орох бөгөөд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироогоор дутагдаж байгаа 24 хуц, 12 ухныг олж, нийлүүлэх ажлыг зохион байгуулсан. Зах зээлд нийлүүлэх, хүнсэнд хэрэглэх малын тооны судалгааг аймгийн ХХААГазарт хүргүүлээ. Судалгаагаар хүнсэнд 5105 мал, зах зээлд нийлүүлэх 13126 мал буюу 808334 тн мах бэлтгэгдэнэ.

Малчдад малчны үнэмлэх, энгэрийн тэмдэг, малчны тамга олгох 5 малчны хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Махны хонь өсгөх 10 иргэнийг 4 бүлэг болгож ахлагч нарыг сургалтанд хамруулж энэ жил 1200 эм хонинд суффолк хуцаар хээлтүүлэг хийхээр болж 24 хуцны захиалгыг өгсөн. Эдгээр өрхийн хургыг ялгуулж эм хонийг тусад нь байршуулах ажлыг эхлүүлээ. Мөн шинээр 6 хуц, 2 ухныг малчдад олгосон.

Сумын засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/93 тоот захирамжийн дагуу 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах нийт 26 хүсэлт хүлээн авсан байна. Мөн газартай холбоотой мэдээллийг 123 иргэнд өгч ажиллаа. Өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 3 өргөдөл, эзэмшил газрын талбай хэмжээ өөрчлөх 3 өргөдөл, газар эзэмших эрх, эзэмших газрын эрх шилжих 2 өргөдөл, газрын барьцаа авах 4 өргөдөл, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг худалдах, худалдан авах 18 өргөдөл, газар эзэмших гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 16 өргөдөл нийт 46 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 14 иргэний газарт Э дугаар авахаар аймгийн Улсын бүртгэл рүү илгээж Э дугаар авсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 16 иргэн, кадастрын зураг хийлгэх 19 иргэн нийт 35 иргэнд үйлчилсэн.

Тайлант хугацаанд 26 иргэнтэй газрын төлбөрийн тооцоо нийлж урьд оны үлдэгдэл газрын төлбөрөөс 862.0 мянган төгрөг төлүүлсэн.

Шинээр гэрээ байгуулсан 4 иргэний газарт газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэн татварын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус суманд 1000 тн багтаамжтай механикжуулсан зоорийг барих чиглэлээр зураг төсөв гаргах тендерт шалгарсан "SKCH" ХХК компанид өвлийн хүлэмж байгуулах 5 га талбайн зураглал үйлдэж хүргүүлээ.

МУЗГ-ын 2018 оны "Тариалангийн бүс нутаг тогтоох" 131 дүгээр тогтоолын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 1 хоршоо, 1 иргэнд махны чиглэлээр суффолк үйлдвэрийн цөм сүрэг хөгжүүлэх 170 хээлтэгч, 3 хээлтүүлэгч олгосон.

"Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Төвийн бүсийн түншлэл 2021" үзэсгэлэн худалдаан тус сумаас 5 ААНБ, 4 иргэн 3 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 12.3 сая төгрөгийн борлуулалт хийгдэж 2 ААНБ, 1 иргэн тус үзэсгэлэн худалдааны тусгай шагнал хүртлээ. Мөн ХХААХҮЯ-аас зохион байгуулдаг "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаан оролцох хүсэлт гаргасан 2 ААНБ, 6 иргэн 3 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 71.1 сая төгрөгийн борлуулалт хийж 1 хоршоо зохион байгуулалт сайтай шилдэг хоршоогоор шалгарсан.

Одоогоор хадлан тэжээл бэлтгэл, сумын аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн нөөцөд 25 тн өвс, 5.0 тн хивэг байна. Мөн сумын хэмжээнд 445 малчин, мал бүхий өрх 9746 тн байгалийн хадлан бэлтгэсэн. Үүнээс сумын нутаг дэвсгэрээс 172 иргэн 4512 тн хадлан бэлтгэсэн. 26 иргэнд шинээр хадлангийн талбайг хуваарилан олгох ажлыг зохион байгуулсан.

2021 онд сумын хэмжээнд 1372 га төмс, хүнсний ногоо тариалснаас 366.4 га талбай усны үерт автаж ургац хураан авах боломжгүй болсон. Нийт 1005.6 га төмс, хүнсний ногоо хураан авахаас төмс 182 га хураан авч 3856 тн ургац, хүнсний ногоо 18 төрлөөр 799.6 га талбайгаас

677.9 га хураан авч 10275.5 тн ургац байна. Нийт дүнгээр 883.9 га талбай төмс, хүнсний ногоо хураан авч 14131.5 тн ургац хураан авч ургац хураалт 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна. 3 ААНБ, 4 иргэний 3 төрлийн ургац хураан авалт хийгдэж 121 хүн хүч ажиллаж байна.

“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын систем”-ийн программ хянаж 11 тариаланчид 6 төрлийн хүнсний ногооны гарал үүслийг олгосон.

Сум хөгжүүлэх сангийн програмд зээлийн эргэн төлөлтийг шивж оруулан одоогоор сум хөгжүүлэх сангийн програмд 51 зээлдэгч байна. Үүнд: Хэвийн 12 зээлдэгч, хугацаа хэтэрсэн 11 зээлдэгч, хэвийн бус 2 зээлдэгч, чанаргүй 26 зээлдэгч байна.

Сумын ЗДТГ-аас Аймгийн Онцгой комисс, УЦУОШГазар, ОБГазраас ирүүлсэн сэрэмжлүүлэг мэдээг хугацаа алдалгүй ЗДТГ-ын мэдээллийн самбараар сурталчилж багийн Засаг дарга малчдын бүлгийн ахлагч нарт утсаар мэдэгдэж, малчидтай уулзалт хийж мэдээлэл өгсөн.

Олон нийтийн цахим сүлжээний “Дархан-Уул аймгийн Орхон сум”, “Орхон Жимс Ногоо Ус-Цаг-Уур”, “Орхон сумын Засаг даргын Тамгын газар”, “Орхон сум Энхтал 2-р баг” гэсэн цахим хуудсаар Улсын Онцгой комисс, аймаг сумын Онцгой комиссоос гаргасан Ковид-19 өвчнөөс урьдчлан сэргийлэх, хамгаалах, тэмцэх талаар авч явуулж байгаа арга хэмжээний талаархи 5 мэдээ, мэдээлэл, цаг агаарын урьдчлан сэргийлэх мэдээ, онц аюултай үзэгдлийг талаар 3 мэдээг хугацаа алдалгүй нийтэлж ажиллалаа.

2021 онд Зөрчлийн хуулийн 7.6. дугаар зүйл 4 дэх заалтаар арга хэмжээ авахуулсан 1 иргэнийг торгууль, нөхөн төлбөрийн 312.0 мянган төгрөгийг төлүүлж ажилласан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд түлшний модны эрхийн бичиг олгох ажлыг 15 иргэнд 60 м.кв мод бэлтгэх эрхийн бичиг олгосон.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд иргэд, ААНБ-аас 23 дуудлага мэдээлэл ирснээс гэмт хэргийн шинжтэй 1 дуудлага мэдээлэл хүлээн авч материалжуулан шалгаж байна.

Хэв журам сахиулах чиглэлээр өдөр болон шөнийн эргүүлийн үүргийг нийт 16 удаа гүйцэтгэж ажиллах хугацаанд нийт 65 аж ахуй нэгж байгууллага, хувь хүнийг 185 удаа шалгаж ажилласан. Ар гэрт нь нийт 13 иргэнийг хүлээлгэж өгсөн. Тайлант хугацаанд 123 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр шалгалт хийж ажиллах хугацаандаа 205 тээврийн хэрэгсэлийг зогсоон шалгаж зөрчил гаргасан 50 жолоочийн зөрчлийг газар дээр нь арилгуулж зөрчилтэй явсан 34 жолоочийг 855.0 мянган төгрөгөөр торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 3 жолоочийн эрхийг хасаж шийдвэрлэсэн.

Сумын Засаг даргын 2021 оны А/41 дүгээр захирамжийн хүрээнд сумын мал сүргийг урьдчилан сэргийлэх 6 төрлийн вакцинжуулалтанд давхардсан тоогоор 27303 толгой мал амьтан хамрагдалаа. Үүнд: Бруцеллёзын вакцинд 272 өрхийн 2965 тугал, 137 өрхийн 8950 толгой хурга ишиг, дуут хавдарын вакцинд 367 өрхийн 8209 толгой үхэр, цусан халдвартын вакцинд 142 өрхийн 4852 толгой үхэр, томуугийн вакцинд 62 өрхийн 1587 адуу, гахайн цусан халдвартын вакцинд 6 өрхийн 740 гахай тус тус хамрагдсан. Захирамжийн биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус сумын хэмжээнд давхардсан тоогоор нийт 115 малчин, мал бүхий иргэнд 23584 кг мах, 257 ширхэг арьс ширэнд, 235 толгой амьд малд мал эмнэлгийн гэрчилгээг мэдрэхүйн эрхтний үзлэгийг тогтмол хийж, хяналт тавьж ажилласан. Малын гоц халдварт өвчин гарсан аймаг сумдаас чиглэсэн малын шилжилт хөдөлгөөн зогсоож, хяналт тавьж ажиллаж байна. Тайлант сард отор нүүдэл, үржлийн чиглэлээр малын шилжилт хөдөлгөөн хийгдээгүй байна.

Улсын хэмжээнд малын гоц халдварт шүлхий өвчин 14 аймгийн 26 суманд, бог малын мялзан өвчин 5 аймгийн 10 суманд, гоц халдварт үхрийн арьс товруутах өвчин 1 аймгийн 5 суманд гарсантай холбоотойгоор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 132 тоот албан тоот бичиг, сумын Засаг даргын А/122 дугаар захирамжийн хүрээнд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт үзлэгт 120 өрхийн 5400 толгой мал хамрагдсан. Үзлэгийн дүнгээр ямар нэгэн өвчний шинж тэмдэг илрээгүй. Шүлхий болон үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 120 өрхөд 2 төрлийн 240 ширхэг зөвлөмжийг хүргүүлж ажиллаа.

ААНБ-ын хог хаягдалд 40.0 мянган төгрөг, 14 ААНБ-ыг цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээг үзүүлж 1.879 сая төгрөг, 48 айл өрхийн цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээ үзүүлж 2.117 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР